

ЧИНГИСЭЭС УХААЛАГ СУРАЛЦАЖ, БҮТЭЭЛЧЭЭР ХЭРЭГЖҮҮЛЬЕ

Д.Хүүхэнбаатар

Монгол Улсын Их Сургууль. Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Их Чингисийн төр барих уран ухаан, нийгмийг өөрчлөн шинэчлэгч, байгуулагч, сөёл эрдмээр удирдах, монгол төгс ухааныг өнөөгийн монголчууд, эрх баригчид судалж, амьдралд хэрэгжүүлж чадахгүй байгааг хэлэх гэсэн юм. Түүхээс суралцахгүй байна.

Түлхүүр үг: Эрч хүчтэй удирдагч, эв эе, даган орсон түшмэг, харилцан итгэлцэх, өнөөгийн Монголыг үнэлэхүй

Мянганы их хүн Чингис хаан үнэхээрийн хосгүй суут ухаантан, төрийн жолоог барьж тодорч товойсон улс төрч, агуу дайчин жанжин болохыг зөвхөн монголчууд төдийгүй хүн төрөлхтөн бахархан шүтэн, бишрэн магтаж байна. Энэ хосгүй их хүнийг хүн төрөлхтний оройн дээд ухаант чандмань эрдэнэ гэхээс яахав. Гэхдээ Чингис хаанаа хоосон магиах нь ихдээд, харин түүнээс сурах нь тааруухан юм шиг санагддагийн учир юун билээ. Тэр аугаа их хүнийг нэг үе, тухайлбал ардын хувьсгалын жилүүдэд харийн хорт муу хүний үгэнд орж, газар доогуур ортол муулж байсан цаг саяхан. 1990-ээд оноос хойш ардчилалын нэр барьсан хэнээрхэл дэгдэж, түүнийг тэнгэрт тултал магтах боллоо. Өөр бүх юм, бараг өмд гутал, архи дарс ч Чингис болж, мөнгөний шуналтан улаан нүдтэний ашиг олж шулан мөлжихийн нэг түрий барих арга саам боллоо.

Нэгэн хөөрхий хүн “Чингис төрөхийг хүсэмжлэн бичсэнийг үзсэнээ санаад аргаа яджээ бид гэж бодож билээ. Өнөөдрийн монголд хүчтэй улс төрчид, жолоодон хөтлөгч (элитүүд, лидерүүд) төрөөгүй байна. Монголоо мэддэггүй (элитүүд, лидерүүд) төрөөгүй байна. Монголоо мэддэггүй (хүмүүс) монголын төр засгийг барьж байна шүү дээ. Энэ бол бидний өөрсдийн буруу. Юу ч мэдэхгүй нялх хүүхдээр гэр малаа толгойлуулсантай адил хэрэг. Чингисийн Монгол, өнөөгийн Монгол хоёр удам угсааны ариун уламжлалтай ч гэсэн хөгжлийн эрс еөр түвшинд байсан ч олон зүйлээр давтагдаж байгаа нь үнэн. Харамсалтай нь Чингис бол агуу их өөрчлөн байгуулагч бөгөөд Чингисийн тэр их шинэчлэлтийг хэрэгжүүлсэн арга барилаас өнөөгийн төр засгийн дээд эрхийг баригчид даанч хол хоцорч монголоо гэсэн арга ухаан муутай (мулгуу дууриамал үндэсний үзэл бодолгүй хойчийг харах, мэргэн холч бодлогогүй) байх шиг санагдаж байна. Тэд түүхээсээ огт суралцдаггүй, мэддэггүй, өндөр алба тушаал зэрэг хэргэмийн төлөө үхэн хатан

зүтгэж, мөнгөнд толгойгоо мэдүүлэн монголоо алдсан шинэ үе хэмээх хүмүүс ард түмнээрээ эх орноороо тоглож, хувийн шунахай эрх ашгаа эрхэмлэх болжээ. Бид үүнээс яаж ангижрах юм бэ? Өөрийгөө засаад гэрээ зас, гэрээ засаад, төрөө зас гэсэн мэргэн сургаал бий. Бодоход өнөөгийн Монголд төмөр нүүртэй, нударга хатуутай төр хэрэгтэй болжээ. Юуны өмнө Монгол улсаа ийм л аргаар төвхнүүлсэн шүү дээ. Тэр үеийн нөхцөлд тэгэхээс ч өөр арга байгаагүй.

Чингис монголын төрт улсыг байгуулахдаа юуны өмнө эв нэгдлийг эрхэмлэсэн нь өөрийн үзэл бодол нэгтэй шинээр төрж байсан тал нутгийн бие даасан чинээлэг сурвалжтануудыг түшиглэн жирийн монгол түмнээ хөл хөдөлгөөнд татан оруулж, тэднийг нягтруулан зангидаж чадаад, түмэн олондоо түшиглэснээрээ агуу их үйлсийг бүтээсэн суут хүн болсон билээ. Чингис эхлээд Монголоо засан төвхнүүлж, нийгмийн амьдралын бүх хүрээнд эрс өөрчлөлт шинэчлэлт хийж чадаад, түүнийгээ улмаар дэлхийн хэмжээнд дэлгэрүүлж чадсан билээ. Тиймээс ч Чингис хаан, дэлхийн хэмжээний илбэн тохинуулагч, засан төвхнүүлэгч өөрчлөн шинэтгэгч гэж бүрэн утгаар нь авч үзэх ёстой.

“Монголын нууц товчоо” нь бүхэлдээ их хэргийг бүтээхийн тулд эв нэгдэлтэй бат нягт ялагдашгүй байхын үндсийн үндэс болох үзэл санааг нэвт шингээсэн гайхамшигт бүтээл мөн.

Алун-гуа таван хүүдээ

- Та нар ганц, ганцаар салбал нижгээд сум мэт хүнд хялбархан дийлэгдэнэ. Та нар эв эеэ нэгтгэвэл тэр багласан таван сум мэт бэх болж, хэнд ч хялбар дийлэгдэхгүй болно” гэж сургасан байдаг. (МНТ.22)

- Хожим Өэлүн эх загаснаас муудалцсаныг дуулаад “Та нар нэг эцгийн хөвгүүд байтал юунд тэгж маргалдана? Одоо сүүдрээс өөр нөхөргүй, сүүлнээс өөр ташуургүй байгаагаа мэдэх биз. Ийм бол бид тайчууд нараас яаж өшөөгөө авч чадна. Урьдын Алун эхийн хөвүүд мэт яагаад эв эегүй болов? Та нар битгий тэг” гэж зэмлэсэн үгийг үл ойшоон Тэмүжин, Хасар хоёр Бэгүтэрч дүүгээ эхийн үгийг сануулж хориглосоор байбал харваж хөнөөснийг дуулаад ихэд хилэгнэн

“Ханиа барагсад

Ижлээ идэгсэд

Халуун хэвлээс гарахдаа

Хар нөж атгаж төрсөн билээ” хэмээн ихэд уурсан хань нөхөдгүй ганцаардаж байхад “та нар юунд ийм хэрэг хийв” (МНТ.78) гэж ихэд хилэгнэн буруушаасан байдаг.

Бас хожим Чингис хаан Хасар дүүгээ буруутган гэсгээн цээрлүүлэх гэж байхад нь Өэлүн таслан зогсоож хатуу зэмлэсэн баримт бий. Энэ бүхнийг дурьдан буйн учир нь Монголчуудын бүхий л түүхийг үзэхэд тархай бутархай аймгуудыг Чингис хаан нэгтгэж 1189 онд суурь нь тавигдаж, 1206 онд нэгдсэн Монгол улсаа байгуулж, улмаар дэлхийн хүчирхэг их гүрэн болоход хүргэсэн. Гэвч цагийн эрхээр салж бие даасан том улсууд болсон бөгөөд өөр зуураа зөрчилдөн байлдах найрамдах зэргээр харилцсаар эцэст нь уусан шингэсэн Халх Монгол орон Юань улсын үед “Давааны арынхан” гэгдэж, Тогоонтөмөр хятадаас хөөгдсөнөөс хойш монгол гурав тасарч билээ. Энэ нь ч цөөхөн Манжид эзлэх боломж олгожээ. Гурван монголын цаашдын хувь заяа харилцан адилгүй. Өвөр монголчууд зарим нь тухайлбал Лигдэн, Халын Цогт тайж нар Манжийг эсэргүүцэн тулалдсаар дарагдсан байхад нөгөө хэсэг нь манжийн ивээлд автан орсон байна. Энэ бол 1636 оны эхээр болжээ. 1580 оны Хорчний ноён Онгудайн тэмцлээс эхэлбэл Цахарын Лигдэн хааны ялагдал хүртэл 38 жил болж байна.

Гэтэл Халх нар хөршийн ёсыг сахин, эвээр аргалахыг гол болгож 1691 онд Долнуурт их чуулганаар хэлэлцэн дагаар орсон нь нэрийн төдий хүлээн тусгаар байдлаа түшмэг байдлаар авч үлдэхийг сонгосон хэрэг. Халхын гурван хаан Өвөр Монголчуудын тэмцэлд оролцоогүй ганцхан Цогт зөрчин хөдөлж Лигдэнг дэмжсэн юм. Халхчуудын манжийн эсрэг тэмцэл Цогт тайжаас эхэлсэн гэж үзвэл 45 жил үргэлжилсэн болж таарна. Үүнээс цааших жилүүдэд байдлыг тандсан зай барьж (1598) тусгаар улсын ёсоор харилцан шалтаг өгөхгүй байх тал нь голлож байжээ. Тэгээд ч Манж нар ч халхчуудын хувьд түшмэг холбоотны бодлого явуулдаг байв. Энэ нь Манж гүрний хятад зэрэг бусад эрхшээлийн орнуудын эсэргүүцлийг Монголчуудын хүчээр дарж байх бодлоготой холбоотой байв. Гурван хаант улс халх 7 хошуу болон хуваагдсан нь манжид ашигтай болж эргэхэд ойрд аймгууд нэгдэж Дөрвөн ойрд болж хүчирхэгжин гарч иржээ. Гэвч бас л дотор зуурын зөрчил, хаан ширээний төлөө өрсөлдөөнөөс болж XIX зууны 1920-иод оны эхээр Хо өрлөгийн торгуудууд Ижил мөрөн хүрч, Орост шургасан шиг 1638 онд Төр байх Гүшхан хөх нуур руу нүүжээ. 1635 онд тэр өөрийгөө бүх Ойрдын хаан гэж

зарлалаа. Дахиад л зөрчил, өөр хоорондын дайн самуун дэгдэж бусдын идэш болох нөхцлийг бүрдүүлж байжээ.

Түүний дараа гарч ирсэн Галдан (1671-1697) ихийг хийх санаа гарган, Орос, Хятадтай найрсаг харилцаа тогтоох гэж оролдож байсан нь буруу биш. Гэвч манж хаантай харилцаа хурцдаж эхэлсэн үеэсээ халхтайгаа нэгдэж, эв эеэ олохыг оролдохын оронд 1688 онд цэрэглэн халдаж довтолсон нь түүнийг ганцаардахад хүргэсэн юм. Энэ нь Халхын ноёдыг манжид даган орох нэгэн шалтгаан болов. 1688 онд манжтай найрамдах санал тавьсан боловч амжилт олоогүй юм. Учир нь манж хаан хүчний давуугаа илт мэдэрч байжээ. Тэгээд ч 1696 онд сүүлчийн манж хаан хүчний давуугаа илт мэдэрч байжээ. Тэгээд ч 1696 онд сүүлчийн тулалдаанаар цохигдон унажээ. Ингэж Монголын сүүлчийн нутаг орон баруун монгол манжид автсанаар Монголчууд тусгаар тогтнолоо алджээ.

XIX зууны II хагасаас манжийн нэр үлдэж үнэндээ хятадад уусан шингэжээ. Халхчууд 1919-1921 оны VIII сард хөрөнгөтний Хятадын харъяат мужаар түр байсан удаа бий. Улааны аюулаас хамгаалах нэрийдлээр хятадууд цэргийн түрэмгийлэл хийсэн нь зүй бус үйлдэл бөгөөд олон улсын харилцааны дэг журмыг бүдүүлгээр зөрчсөн балмад явдал мөн. 1911 оны цагагачин гахай жилийн хувьсгалаар манжийн төр унахаас өмнөхөн гадаад монголд үндэсний эрх чөлөөний хувьсгал ялж, тусгаар тогтнолоо зарласан нь онцгой ач холбогдолтой түүхэн эргэлт билээ. Гэвч түүний цаашдын хувь заяа эрээнтэй бараантай байлаа. 1911-1915 он хүртэл тусгаар тогтносон байдлаа хамгаалж хятадтай тулалдаж байв. Орос хятад хуйвалдаж Хиагтын гэрээ гэгчийг хийж Монголчуудыг хятадын автономит иуж болгон хүчээр тулган хүлээлгэсэн гунигт хэрэг болов. Гэрээнд оролцсон монголын төлөлөгчид дипломат аргаар тусгаар улс байхаа тууштай хамгаалж байсан юм. Автономит (өөртөө засах) болсоныг бас оргүй үгүйсгэж болохгүй. Ухралт хэдий ч бас тэр дайтай үлдсэн нь чамгүй хэрэг байсан юм. 1919-1921 оны VII сард дотоод муж болж байснаас хавьгүй дээр гэж болно. Монголчууд Орос хятадтай харилцан сурсан арга ухаантай, тэдний зөрчлийг овжин ашиглаж сурсан учраас гадаад бодлоготоо их улсыг түшиж харилцан бага улсын ёсоор орших гэдэг зарчмыг бий болгон хэрэгжүүлж чадсан улс. Америкийн төрийн тэргүүн Ж.Буш Америк, Монгол улсын гурав дахь их хөрш болох тухай онцлон дурьдаад, харилцан итгэлцэхийг уриалсан явдал нь өнөөгийн дэлхийн улсууд, түүний дотор хүчирхэг их гүрнүүд хэрхэн өндрөөр үнэлдэгийг манай улсын нэр

хүндийг илтгэн харуулав. Бас Монгол, Америк хоёрт адил төстэй зүйл бийг хэлээд монголоос суралцах тухай бараг анх удаа тод томруун томъёолсон гэж болно. 1921 оны хувьсгалаас өмнө монгол үндэстэн мөхөж, сөнөж байсан гэдэг үзлийг өөрөөр үзэх шаардлагатай. Бүгдийг харлуулан ард түмнийхээ эх түүхийг гуйвуулж болохгүй нь илт байна. Гадаад, дотоод бодит хийсвэр олон шалтгаанаар өндөр хөгжилтэй орнуудын хөгжлийн төвшнөөс хоцорсон хэдий ч монголчууд дэлхийд бэлчээрийн сонгодог мал аж ахуйг бий болгосон ганцхан ард түмэн. Түүнийг дагаад онцгой содон соёл, ёс заншил, шашин шүтлэг, шинжлэхүй ухааныг бий болгож чадсан хаана ч, хэзээ ч давтагдашгүй зүйлсийг бүтээсэн билээ. Газар усаа, ан амьтнаа хайрлан хамгаалах эрхэм ёсыг эртнээс эзэмшин дагаж ирэхэд хүргэсэн бөгөөд газар хагалж, уул уурхай ухаж чухам л шавар хотдоо шавааралдан суудаг, суурьшмал орнуудыг бодвол монгол газар орон байгалиа цөлмөн эрэмдэглээгүй, харьцангуй цэлмэг тунгалаг хөх тэнгэрийн орон хэвээр үлдсэн билээ. Амьдрах ёс, уул усаа тахих ёс монголчуудад байсаар байсан нь нүүдэллэн амьдрах ёсны хууль юм. Энэ бол мухар сүсэг, далдын хүчинд итгэх төдийн зүйл биш агуу их сургаал, тэнгэр хангайгаа хамгаалах тогтсон хатуу журам, бат хатуу ёс дэглэм байлаа. Энэ бол амьдрах сонгодог арга ухаан бөгөөд бөө мөргөлийн мөн чанар нь үүнд чиглэгдсэн гэж хэлж болно. Монголчуудын уран барилга орон сууцны салбарт бүтээсэн нэг гайхамшиг бол монгол гэр мөн. Гэр нь барих, буулгах, ачин тээхэд хөнгөн төсөр, үрэгдэл зардал бага, халуунд сэрүүн, хүйтэнд дулаан, эрүүл ахуйн хувьд маш тохиромжтойгоор гайхагддаг. Сархинаг тоонт, хатгуур тоонт, гэр тэрэг мэтийг бүтээжээ. Гэрийн нэг онцлог нь газар хөдлөлт, салхи шуурганд туйлын тогтвортой сууц. Урлаг, урлахуй ухаанд монголын өөрийн гэсэн дүр төрхийг оруулсан, үнэхээр алдаршуулан түгээж дэлгэрүүлүүштэй зүйлс олон бий. Хоёрхон хялгасан чавхдсан дээр хорвоог дуулдаг морин хуур, Монголын цээл сайхан уртын дуу, хөөмий исгэрээ, хуруу, дэмбээ, зээгт наамал, хээ хуар өөр хаа байдгийг би мэдэхгүй юм. Ямар ч гэсэн монголын гэж хэлэхэд нэг л их буруудахгүй байх гэдэгт итгэнэ. Байгальтай, малтай үг хэлээ ололцон, эдэлж, маллан, зохицуулж чадах ухаанаараа гайхагддаг. Од гариг, хувилахуй хийгээд анагаах, тооцоолох, хийчийг харах, зөгнөл төсөөлөл, зөн совингоор тайлах, ааш араншин, царай, зүсээр нь аливааг тодорхойлж таньж чаддаг нь гоц.

Монголчууд 5 хошуу малыг сонгон эрхэлсэн нь туйлын сонирхолт яагаад гахай, тахиаг эрхлээгүй юм бол, тэд нь их хэмжээний идэш тэжээл шаарддаг, 4 улиралын хүнд цөхцөлд тэсвэр багатай, бас уналга, зүтгэх хүчин болж чаддаггүй. Монгол мал бол бэлэн тэжээл шаарддаггүй, бэлэн орон байр хэрэглэдэггүй, байгалийн шим, ус ургамалыг өөрөө сонгон идэж уудаг, чухам бүхэл бүтэн үйлдвэрлэл гэж хэлж болно. Монголчууд 5 хошуу малыг бий болгоёон нь үнэхээрийн хосгүй бөгөөд зэрлэг адгуусыг гаршуулж, гэршүүлж, улмаар сайн угсааны үүлдрийг түүхэнд анх удаа мал аж ахуйг үүсгэн хөгжүүлж, тэр нь монголын нийгмийн хөгжлийн эдийн засгийн үндэс болж чаджээ.

Дэлхийн улс орнуудын төр тогтолцооны түүхэнд оруулсан их хувь нэмэр бол түрүү үеийн төрт ёсны зарим уламжлалаас авч нүүдэлчдийн төрт ёсыг үндэслэн байгуулсан нь Чингис, түүний шадар ноёдын нэг гавъяа билээ. Нүүдэлчний нийгэмд төр засгийг төвлөрүүлэн зангидсан удирдах хаан зайлшгүй бөгөөд төр засгийн хэрэгт ард нийтийг оролцуулж өргөн олны санал хүсэлтийг түшиглэх явдал чухлыг анзаарч хааны дэргэд улсын их хуралдайг (парламент) бий болгожээ.

Их засаг (Яса) үндсэн хуулийг бий болгож, түүнийг мөрдүүлэх үүрэгтэй “Сэцдийн зөвлөл” байгуулжээ. Төр, цэргийн зохион байгуулалтад аравтын тогтолцоог тогтоов.

Аравтын систем нь нэг хүн 10 хүнтэй ажиллах чадвартай байдгийг ухаалгаар ашигласан хэрэг бөгөөд энэ нь дэлхийд түгэж дэлгэрсэн туршлага, үлгэр дууриал болсон учир нь Чингисээс сурах гэдэг нь монголоосоо сур гэсэн үг. Аугаа их энэ хүн заахдаа “Дэлхийг морин дэл дээгүүр байлдан дагуулж, эзэлж болно, харин дэлхийг морин дэл дээрээс захирч болохгүй” гэсэн нь өөрөөс нь өөр хэн ч халах аргагүй (хэн ч хэлэх эрхгүй) гэгээн сургааль болсон юм. Нээрээ ч хэн ч хэлэх чадалгүй, хэлэх ч ямар ч үндэсгүй. Үүний дэргэд Македон, Наполеон, Гитлер юу ч биш. Тэд хүний хүчний илүүгээр, зэвсэг техникийн давуугаар, сүрдүүлгээр ялалт авна гэж боддог зүтгэдэг байсан бол Чингис хаан, монголчууд үүний зэрэгцээ ухааныг тэргүүнд тавьдаг байсан нь ялах дийлэхийн шүтээн болгодог байсанд оршиж байжээ. Тийм учраас суут өөрчлөн байгуулагч, шинэчлэгч (реформатор) байсан билээ. Харамсалтай нь түүний ертөнцийг шинэчлэн хувьсгахын агуу их өөрчлөлтийн тухай тун дулимагхан ярьсан байна. Тэгэхээр түүнээс яаж суралцах билээ. Улмаар бүтээлчээр хэрэгжүүлж хөгжүүлэх тухай яриа ч сайн болохгүй нь мэдээж. Их Чингисийн нийгмийг өөрчлөх, шинэчлэх холч

бодлогыг түүнийг залгамжлагчид тууштай хэрэгжүүлж өөрчлөн шинэчилсэн их зүйлийг бүтээжээ. Хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд ихийг бүтээж, бодит байр эзлэн өвөрмөц хувь нэмрээ оруулсан ард түмэн гэдэг нь тодорхой байна.

XX зууны эхээр монголчууд хүлцэнгүй толгой гудайн сууж байгаагүй, харин улс үндсээ сэргээн мандуулахын төлөө шургуу тэмцэж байсан шинэ үе. 1911 оны ҮЭЧХ, 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал нь үргэлжилсэн шинжтэй Ардын хувьсгалын ялалт нь Монголын ард түмний эв нэгдлийн зүй ёсны үр дүн мөн.

Чингисийн 1911, 1921 оны хувьсгалын ялалтын үндэс нь гагцхүү үндэсний эв нэгдэл байсан атал өнөөгийн монголын төр засаг урьдын үнэт туршлагыг хэрэгжүүлж огихон ч чадаагүй байна. Хэн нэгэн цадиггүй этгээд амандаа орсноо чалчиж, олныг үйлмүүлэн чухамхүү дураараа дургин байгааг иргэдийн жагсаал, цуглаан, өлсгөлөн суулт, хэвлэн нийтлэх, үг хэлэх эрхийг хангаж байгаа мэтээр тайлбарлаж байх юм. Үндэсний эв нэгдлийг, иргэдийн эрхийг төрөөс зохион байгуулж, залж чиглүүлэх ёстой.

Ардын хувьсгал эхэлсний дараахнаас эхлэн Бодоо, Данзангийн тэрсэлдээн дараалан толгойгоо алдсанаар төгссөн. "Баруунтан", "зүүнтэн" гэгч гарч, улмаар улс төрийн намаа хагалан бутаргаж, үндэсний зөв шугам баримталсан хүмүүсээ "баруунтан" болгон улмаар дайсанд үзэж гаднын түлхээсээр егүүтгэн үгүй хийсэн шүү дээ. Нам, төр, засгийн эрхэнд гарсан зүүн коммунизмын балмад этгээдүүд нугалаа завхрал, хэтрүүлэг хэлмэгдүүлэлтийг гааруулав.

Тэд монголын нэрт хутагт хувилгаадыг Монголын өнцөг булан бүрээс хамгаалах нэрээр татан авчирч тэдний олонхи нь хорлогдон талийжээ. Хуучны харгис, феодал, түшмэд хэмээн бас чинээлэг ардуудыг ч хамруулан мал хөрөнгийн нь хураасан нь амьдарч оршин тогтнох үндсийг таслан, хомроглон устгасан аймшигт аюул тарив. Шашны сүм хийд лам нарын хувьд бас дайсанд үзэж сүм хийдийг эвдэн нурааж, бурхан тахил, ном судрыг шатаан устгаж сүжиг бишрэлийг гутаан доромжлов. Сүм хийдийн лам нарыг хүчдэн тарааж, хүчээр хар болголоо. Их хэлмэгдүүлэлтийн үед 1920-иод мянган гэмгүй лам нарыг хилсээр хэлмэгдүүлэн хөөрхий болгов.

Хий хоосон социализм байгуулна гэж хийрхэн, хамтрал, коммун гэгчийг албадан байгуулан, малчдын хөрөнгийг цөлмөн хурааж сүйрүүлжээ. Түүний дээр дааж давшгүй алба татвараар дарж байлаа. Дээр дурьдсан гунигт баримтаас үзэхэд эхний хориод жил монголчууд хэр зэрэг эв нэгдэлтэй баж вэ? Харин нам

төр улсын удирдлага, ард түмний хооронд ан цав гарч, ард олныг зэвсэг барин босож, цус урсган тэмцэхэд хүргэж, төрөлх эх нутгаасаа дүрвэн зайлж цагаачлахад хүргэсэн байна. Дүрвэгсдийн нэг дуунд:

“Нүүгээд явчихсан бидний нутаг
Нүүгэлтэн бараантаад хоцорлоо хөөрхий
Нүүн яваагаа бодоход
Нүдээр дүүрэн нулимс бүрхэх юм аа
Харийн нутагт очихоо бодохоор

Хатуухан төрдөө гомдох юм аа хөө” хэмээн гуниглан дуулж явсан гэдэг. Үүнд хэн буруутай вэ? Гэдэгт дууны үг бэлээхэн хариу өгч байна. 30-аад оны сүүлчийн хагаст болсон Их хэлмэгдүүлэлт гэдэг галзуурсан хядлага болсон. Энэ нүгэлт хар шуурганаар бүрэн бус мэдээгээр 30 гаруй мянган алтан амийг авч оджээ. Энэ егүүтгэл 1932 оны ардын эсэргүүцлийн хариу юу? Энэ нь алсын удирдлагатай нэрийн төдий тусгаар улс байлган нөлөөний орноо болгох хорт бодлогын уршиг. Үндэсний шугамаа баригсадыг, эрх чөлөөтэй монгол түмний эрмэлзлэлийг нухчин дарах үйл ажиллагаа бөгөөд үүнээс үүдэн иргэний дайн (үндэсний дотоод тэмцэл) болсон гэж болох юм.

Чухамдаа энэ нь өөрийн гар хөлийн үзүүр болгосон ч хэт зүүний балмадуудыг ашиглан (бас тэд шилэндээ буу тулгаастай байсныг мартаж болохгүй) монголыг монголоор нь номхотгосон хэрэг байв.

Өчүүхэн би үүнийг бичихдээ Зөвлөлтийн ард түмнүүд Оросын ард түмний хүнд бэрх үед бидэнд үзүүлж чухам ахын гараа сунгасан их тусыг үгүйсгэх хар санаа агуулаагүйгээ ялдамд өчье. Дурьдан буй үед Монгол дандаа буурч, будилж байгаагүй ихийг бүтээсэн. Тусгаар тогтнолоо хэвээр үлдээж, батлан сахиж, улс ардын аж ахуй, соёлоо хөгжүүлэхэд багагүй алхам хийн ахиц гаргасныг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Монголчууд эвсэж, нэгдэж, хүчээ нэгтгэж чаддаг ард түмэн. Монгол хүн монгол болж төрсөндөө үнэхээр бахархлаг нт цаанаа гүнзгий учир холбогдолтой.

Монгол хүн хол суувч, ямагт элэг зүрхээрээ уяатай эгээрэн мөрөөдөж байдаг шиг алс холоос морь мал нь түмнийг гатлан эх нутагтаа гүйж ирдэг. Алс Европт байлдан байгаа баруун фронтоос, алс өмнөдийн Вьетнамаас эх нутагтаа гүйн ирсэн, хил зөрчигчдийг илрүүлэн барьж авчирсан хилчин тэмээг санахад нулимс унагахаас аргагүй. Монгол нээрээ л ид шидийн ариун, дагшин орон.

Үнэхээр л Төв Ази, Монгол газар нутгаас амьдрал, адгуус амьтан, хүн төрөлхтөн үүссэн өлгий нутаг болохоор бид үүгээрээ бахархахгүй юм бол юүгээрээ бахархах билээ гэж хэн нэгний үгийг хэлэхдээ ичмхгүй. 1930-аад онуудад байсан Шинэ эргэлтийн жилүүдэд, Халх голын дэлхий дахины ач холбогдол бүхий тулалдааны үед, дэлхийн хоёрдугаар дайны хүнд цагт дайны дараах гадаад байдлаа бэхжүүлэх явцад монголчууд эв эеийн хүчээр бэрхийг давжээ.

1945 оны бүх ард түмний санал асуулга, 1946 оны Монгол-Зөвлөлтийн найрамдалын гэрээ үүнийг гэрчилнэ. Монголоо гэсэн сэтгэлтэй хэдий ч хэрхэн яаж хөгжүүлэхээ мэдэхгүй хүмүүс: 1944 онд Жамбалдорж, 1950-иад оны эхээр хэдэн сэхээтэн Монголыг ЗХУ-ын бүрэлдхүүнд нэгтгэх тухай санал гаргаж байсныг үгүйсгэх аргагүй. Энэ нь ирээдүйдээ, өөрийн ард түмний хүчинд үл итгэсэн цөхрөнгөө барсан хэрэг боловч улсаа хөгжүүлэх гэж арга зам эрэлхийлсэн явдал бөгөөд үндэсний тусгаар тогтнолд үнэндээ харшилсан гаж явдал гарчээ.

Тэд долоо, найман Монголыг ЗХУ-д дагаж орох шалтгааныг тодорхойлсноос үзэхэд монголын ард түмний бүтээлч хүч чадалд үл итгэн болгоомжилсон хэрэг бөгөөд түүхэн туршлагаасаа сурах чадваргүй бүтээлч сэтгэлгээгүй хүмүүс байжээ. Монголын уламжлалт гадаад бодлогын үндэс болох их улсыг түшиглэн, харилцан туслалцаж, бага улсын ёсоор оршин тогтнохын учрыг олоогүй байсан бололтой. Түшнэ гэдэг даган ороод бүрэлдхүүнд нь багтан бусдын гар харна гэсэн үг огтхон ч биш ээ. Бас Монгол орноо хөгжүүлнэ, нөгөө социализм байгуулах зорилт, итгэх итгэлээсээ ухарч, улсынхаа хувь заяаг золиослон бусдын хүчинд дулдуйдахад хүрсэн гэж үзэж болмоор.

1950-иад оны дундуур сэхээтний төөрөгдөл гэгч гарч дуулиан дэгдээв. МАХН, төр засгаас улс орныхоо төлөө санаа тавьж, саналаа нууж цэрвэлгүй хэлсэн ухаант сэхээтнүүдийг төөрөлдсөн, итгэж үл болох, намын эсрэг бүлэг, үндсэрхэх, үгүйсгэх үзэлтэн, Монгол-Зөвлөлтийн найрамдалд харш гэдэг нэр хаяг зүүж хяхан хавчиж хэлмэгдүүлж байлаа. Энэ бусармаг үйл ажиллагаа 1980-аад оны дунд үе хүртэл үргэлжилсэн. Энэ хугацаанд феодал ангийг устгаад найрамдалт хоёр ангиас монголын нийгэм бүрэлдэх боллоо гэсэн авч хувийн өмчтнийг үл итгэн мөлжлөг төрүүлэх үүр уурхай гэж үзэн нэгдэлнүүлэх (хоршоолох) хөдөлгөөн гэгчийг сайн дурын үндсэн дээр явуулна гэсэн боловч хэрэг дээрээ албадан шахаж нэгдэл гэгчид нийтээр нь хамруулж, хувийн өмчит малчид үгүй болж, хамтын өмчит нэгдэлчид гэж нэрлэгдсэн нийгмийн шинэ бүлэг

бий боллоо. Хуучин малыг хувиараа өмчлөн, хувиараа эрхлэх мэдлээ алдаж, хамтын өмч нэртэй нийгмийн тогтмол өнгийхөд хүрчээ. Энд хамтарч хоршихыг буруутгаж байгаа юм биш ээ, гагцхүү буруу замаар будаа тээж “хэт зүүний” санааны зоргоор хэрэгжүүлсэн хэтрүүлгийг хэлж байна. Өөрийн гэсэн юмгүй, хувийн ашиг сонирхол дээр үндэслэсэн өмчгүйгээр хүн, айл гэр, нийгэм оршин тогтноход бэрх. Ер ХХ зуунд монголчууд зөв юмыг сэдэж хэрэгжүүлэхдээ ямагт аргаа олохгүй хэрэгжүүлэхээр оролдож бүтэлгүйтэж мухардаж байсан байх юм. Энэ бол монголоо мэддэггүй, монголын онцлог, түүхэн туршлагаасаа суралцаж чаддаггүйтэй холбоотой. Өөрийн толгойгүй бусдыг даган дуураисаар ирсэн нь ийм болгоход хүргэсэн. Монголд нэг хүнийг тахин шүтэх явдал газар авч, хүнд сурталд автан уусч, төр засгийн нүсэр аппарат, захиргаадал дарангуйлж, МАХН, төр засгийн үүрэг гүйцэтгэж, нэг намын дэглэм тогтлоо. Намын гишүүн болох нь зэрэг тушаалд дэвших, алдар хүнд олох гол нөхцөл болжээ. Үүнийг дагаад монголын нийгэмд хуучин харгис түшмэд гэгчдийн оронд МАХН, төрийн албан хаагчид тогтжээ. Хүмүүсийг хөдөлгөн удирдах ажлын гол арга нь захиргаадалт боллоо.

Хүний эрх, тэгш эрхийн тухай хуулинд байх авч тэр бүр хэрэгжүүлж чадахгүй байлаа. Харин ч монголын нийгэмд дарга нар гэдэг хүнд суртлын давхрааг бий болгожээ. Дарга нар бүтээхээсээ зүгээр суух нь их. Тэгээд ч гадаадынханмонголыг дарга нарын орон гэсэн нь оргүй зүйл биш, нэг төрлийн шимэн сорогчид болжээ.

Монголчууд ихийг хийж бүтээсэн ч үр дүн нь бүрэн төгс биш учир дутагдалтай, сайны хажуугаар саар зүйл заавал дагуулж байжээ. Ажил хийсэн хүн алддаг гэдгээр үүнийг цагаатгаж болохгүй нь мэдээж, хар цагаанаар нь бодитой гаргах ёстой. 1980-1990 оноос хойш ардчилал шинэчлэлт нэрээр ардчилсан хүчин нэг намын системийг буулгаж, урьдах үеийн гажигийг засах гэж олон зүйлийг сэдэж, түүнээ хувьсгал хийж байна гэж үзэж байлаа.

Хэрэг явдал цаашид гүнзгийрэхэд нөгөө л гажуудал, хэтрүүлэл, хийрхэл давамгайлж хүссэн үр дүн багатай боллоо. Зуун ямаанд жаран ухна гэгчээр энэ олон нам, хүчин монголоо тал тал тийш нь чангаах боллоо. Ардчилал нэрэр дураар дургиж, төр засаг хуулиа дээдлэхийн оронд сөрөг зогсож гар далайх боллоо. Ардчиллын нэр барин нийгмийн шаарууд даварч, урьд бүтээснээ бүрэлгэж, улс төрийн аллага, авилгал, хуйвалдаанд мэдүүлж өнөөгийн монголын нийгэмд цөвүүн цаг нэгэнт иржээ.

Чингис хаан, түүний шадрууд, төрийн зүтгэлтнүүд юуг яаж хийхээ гайхалтай нягталдаг байсан бөгөөд Амар түүхчийн хэлснээр тэдний агуу их ялалт амжилтын үндсийн үндэс бол гйахамшигтай хатуу сахилга бат, удирдах, удирдуулах ёс, үүрэг хариуцлага, дэг журам байжээ. Нууц товчоонд “цэр нь цээжиндээ, бөөр нь бөгсөндөө” гэсэн мэргэн үг бий. Тэгвэл энэ нь эсрэгээр илэрч өнөөгийн монгол хөл толгойгоо алдаж, эх захгүй задгайрчээ. Ардчилал гэдэг дураараа дургихын нэр биш, харин ч хатуу дэг журмыг нийтээр сахин биелүүлэх явдал.

Ардчилал гэдэг нь бүрэн утгаараа хэзээ ч байж чаддаггүй, туйлын харьцангуй ойлголт. Ер нь засаг төрд гарсан тодорхой хүчин аль нэг хэсгийн хүсэл зоригийг илэрхийлэх бөгөөд бүх нийгмийн анги давхрагын төлөөлөгч байж чаддаггүй, нэгийг дэмжинэ, нөгөөг хохироож байдаг. Ардчилал бол хэлбэрийн төдий зүйл бөгөөд тухайн хүчин, анги бүлгийн хүсэл эрмэлзлэл, эрх ашиг, бодлогыг хэрэгжүүлэх нэг арга болж хэлбэрдэх, дүр эсгэх нь гололдог. Манай бүх нийгмийн чөлөөт сонгууль дээрээс нь зааж томилсон хүнийг сонгосон болдог. Ардууд, олон түмэн дотроосоо нэр дэвшүүлж сонгож байсныг бараг мэдэхгүй юм. Одоо бүр ч саналыг ядууамьдралын нь далим болгон мөнгөөр худалдан авах явдал болжээ. Тэгж засаг төрийн эрхэнд гараад юу хийж бүтээв. Тийм гэж хэлэх тоймтой юм даанч алга даа. Хий цэцэрхэж, нэр төр, алдар гавъяа байр суурь хөөцөлдөж цаг үрж алмайрахаас хэтрэхгүй тодорхой хөтөлбөрөөр хөдөлж дуугардаг төмөр хүн (робот) шиг санагддаг. Гэхдээ тэдний дотор монголоо алдаагүй, эрүүл сэтгэдэг хүмүүс цөөнгүй бийг үгүйсгэхгүй ч найдлага тавьчихаар итгэл өгчихөөр хүн төдий л ажиглагдахгүй байна.

Монголоо алдсан гайхлуудын толгой дээрээ гаргасан нь сонгогч олон бид буруутайг бас хүлээх ёстой. Ерөнхийлөгч, Их хурал, засгийн газрыг огцрохыг шаардаад байгааг үндэслэлгүй зүйл гэж үзэх аргагүй. Байдал хурцадсаар байна. Энэ нь эцэстээ юунд хүргэх бол. Муугаа үзэхгүйн тулд бид юу хийх хэрэгтэй вэ? гэдэг амин чухалд хүрээд байна. Бидэнд одоо ухаалаг бодлого, эрс эргэлт, шийдвэртэй үйл ажиллагаа, эв нэгдэлтэй хүчийг бүрэлдүүлж хөдлөх хэрэгтэй байна. Монголын хувь заяаг монголчууд л аварна. Ингэхийн тулд Чингис шиг удирдагч, түүнийнөхөд шиг ухаалаг, эрүүл саруул, хүчирхэг хүч хэрэгтэй байна. Тийм хүч бий болж байгаа гэж итгэдэг. Улс төрийн янхануудыг үтэр өшиглөн зайлуулж, хүндээр гэсгээн цээрлүүлж, хууртаж ханадаггүй ард олныхоо нүдийг

нээх цаг болжээ. Төмөр нүүр, хүнд нударга гаргах төр засаг үгүйлэгдэж байна. Алгуурлавал алдсаар, хохирсоор эцэстээ мөхнө.

Чингис суут их хүнийг бахархан магтахаасаа илүү нягтлан судалж суралцан, бүтээлчээр хэрэгжүүлэхэд хэргийн учир оршино. Тэгвэл Мөнх тэнгэрийн хүчин дор хөх Монгол мандах болно.

Резюме: Чингис хан великий реформатор, новатор, создатель. У Чингиса современные монголы надо учиться творческий осуществить его учения.